



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар A/328

Хэрлэн сум

Нийлэг хальсан уутны  
хэрэглээг хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтууд, Засгийн газрын 2018 оны “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” 189 дүгээр тогтооцыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх зорилгоор аймгийн нутаг, дэвсгэрийн хэмжээнд бүх төрлийн нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар хэрэглэхийг хязгаарласугай.

2.Нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар хэрэглэхгүй, ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээг олон нийтэд мэдээлэх, сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Ганбаатар), хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газар (Ж.Энх-Амгалан), Байгаль орчин аялал жуулчлалын газар (Б.Дархантөр), сумдын Засаг дарга нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

Нийлэг хальсан уутны хэрэглээг хязгаарлах  
талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050", дунд хугацааны бодлогын баримт бичиг "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг хөгжлийн бодлогын баримт бичигт хог хаягдлын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах, үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, дахин боловсруулах замаар ил задгай хог хаягдлыг багасгах, хөрсний бохирдлыг бууруулах нь нэн шаардлагатай тулгамдсан асуудлын нэг болоод байна.

### 2. Зорилго

2.1. Үйлдвэрийн анхдагч савлагааны зориулалттай уут, хүнсний скоч, хогны зориулалтын уутнаас бусад бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар хэрэглэхийг хязгаарлах, ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, орчны бохирдлыг бууруулах зорилготой.

### 3. Хамрах хүрээ

1.1. Хэнтий аймгийн 18 сум, 5 тосгоны худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд.

### 4. Хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Дор дурьдсанаас бусад бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар хэрэглэхийг хязгаарлаж, ил задгай хог хаягдал үүсгэхийг хориглоно. Үүнд:

-Үйлдвэрийн

анхдагч

Үйлдвэрээс тухайн бүтээгдэхүүний бүрэн

савлагааны зориулалтын уут

бүтэн байдал, чанарыг хангах зорилгоор

ашиглах анхдагч савалгаа боодол

## 2.

-Нийлэг уутыг орлуулах цаасан уут, картон сав баглаа, боодол худалдан борлуулах, түүгээр үйлчлэх, үйлдвэрлэх (гэрээт борлуулалт хийх г.м)

-Дахин ашиглагдах боломжтой бүх төрлийн даавуун уут, сав баглаа, боодлын худалдаа, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

-Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, зориулалтын хогийн саванд түр хадгалах

1 удаагийн зориулалттай сав баглаа, боодлыг ил задгай ээлтэй, дахин боловсруулах боломжтой цаасан бүтээгдэхүүнээр орлуулах

Жижиг дунд оёдлын үйлдвэрүүд даавуун уут, сав баглаа, боодол оёж үйлдвэрлэх, худалдаа үйлчилгээний байгууллагаудад нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулах

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүх нийтээрээ үүсэх хог хаягдлыг анхдагч эх үүсвэр дээр нь органик, энгийн, аюултай, бусад гэсэн 4 ангиллаар ангилж, ялгах

Ангилсан хог хаягдаа зөвшөөрөгдсөн цэгт тулаах эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад хүг ээлгэж өгөх

## 5. Төрийн байгууллагын эрх, үүрэг

5.1. Байгальд ээлтэй даавуун болон цаасан уут үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын санал санаачлагыг дэмжинэ.

5.2. Арга хэмжээний хэрэгжилтийг олон нийтэд сурталчилах, сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

5.3. Цаасан сав баглаа, боодлын үндэсний хэмжээний томоохон үйлдвэрлэгчидтэй холбоо тогтоох, салбар, борлуулалтын цэг байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

5.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ангилсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт төвлөрүүлэх, пресслэх, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

5.5. Арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавина.

## 6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

6.1.4.1-д зааснаас бусад бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар хэрэглэхийг 2022 оны 8 дугаар сарын 01-ээс эхлэн бүрэн хязгаарлана.

3.

6.2. Байгальд ээлтэй бүх төрлийн даавуун болон цаасан уутыг хэрэглээнд нэвтрүүлж, худалдах, үйлчлэх, импортлох, үйлдвэрлэх, хэрэглэхийг дэмжиж ажиллана.

6.3. Зориулалтын хогийн сав байршуулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшинэ.

6.4. Ангилсан хог хаягдлаа зөвшөөрөгдсөн цэгт тушаах эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч, ил задгай хог хаягдал үүсгэхгүй байна.

6.5. Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7.Хяналт, хариуцлага

7.1. Арга хэмжээний хэрэгжилтэд сум, багийн Засаг дарга нар, холбогдох хяналтын улсын байцаагчид хяналт тавина.

7.2. Холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага ногдуулна.